



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020 оны 07 сарын 22-ны  
өдрийн 423 дугаарт бүртгэв.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 495


Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Валютын зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйл, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Дээрх журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.12 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151806001436

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн  
495 дугаар тогтоолын хавсралт



## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлох, гадаад валютын арилжааны мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, гадаад валютын арилжаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2 Санхүүгийн зохицуулах хороо нь Валютын зохицуулалтын тухай хууль болон энэ журмаар тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

### ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-ын ажлын байранд дараах шаардлагыг тавина:

2.1.1. ажлын байрны аюулгүй байдлыг хангасан байх;

2.1.2. санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор дүрс бичлэгийн техник хэрэгсэлтэй байх ба дүрс бичлэгийг нэг сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын системтэй байх;

2.1.3. валют шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

2.1.4. валютыг худалдан авах, худалдах ханшийг электрон самбар болон цахим талбараар нийтэд ил тод мэдээлдэг байх;

2.1.5. төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдсон байх.

2.2. Цахим систем ашиглаж гадаад валютын арилжаа эрхлэх тохиолдолд энэ журмын 2.1.1-2.1.3-т заасан шаардлага хамаарахгүй болно.

2.3. Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

2.3.1. удирдлага, ажилтан нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны сургалтад хамрагдсан байх ба ажилтан нь хуурамч мөнгөн тэмдэгтийг таньж мэдэх чадвартай байх;

2.3.2. харилцагчийг таньж мэдэх зорилгоор Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд нэвтэрч хурууны хээ болон хуулийн этгээдийн регистрийн дугаараар баталгаажуулах;

2.3.3. харилцагч нь гадаадын иргэн, хуулийн этгээд бол иргэний паспорт, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг хуулбарлан авч баталгаажуулах;

2.3.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20-д заасан нэгдсэн системд бүртгэгдсэн байх;

2.3.5.энэ журмын 2.3.4-т заасан нэгдсэн системд холбогдох баталгаажсан тоног төхөөрөмж бүхий хэрэглэгчийн системтэй байх;

2.3.6.гадаад валютын арилжаа хийх тухай бүрд хэрэглэгчийн систем эсхүл цахим төлбөрийн баримтын системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг арилжаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх;

2.3.7.хэрэглэгчийн системд бүртгэгдсэн гадаад валютын арилжааны гүйлгээний мэдээллийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.3-т заасны дагуу гурав хоногийн дотор нэгдсэн системд илгээдэг байх;

2.3.8.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах;

2.3.9.ажилтан нь мөнгөн тэмдэгтийг тухай бүр хянах бөгөөд гүйлгээнээс хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлсэн тохиолдолд гүйлгээг зогсоож, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх;

2.3.10.гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцагчийн мэдээллийг бусдад өгөх, задруулах эсхүл хувийн зорилгоор ашиглахгүй байх;

2.3.11.гадаад валютын арилжааг пос төхөөрөмж, бэлэн бус гүйлгээгээр хийх тохиолдолд ББСБ-ын харилцах данснаас бусад дансыг ашиглахгүй байх;

2.4 Гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын салбар нэгж нь энэхүү журмын 2.1 болон 2.3-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

#### ГУРАВ. ХАРИУЦЛАГА

3.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.